

**НИЙЛМЭЛ ХЭЛЦ БҮТЭЭВЭР ДЭХ ОРУУЛБАР  
ДЭД БҮТЭЭВРИЙН НЭГ ЖИШЭЭ**

М.Базаррагчаа  
/МУИС/

Монгол хэлнээ үйл үгээс тэмдэг нэр бүтээх “-mtayai...” хэмээх дагаврыг В.М.Котвич “тухайн үйл хэрэгт чадамгай байх төдийгүй байнга хичээмтгий байх”<sup>1</sup>; А.Попов “үйл үгээс үүсэх тэмдэг нэр (хавсрал нэр) нь үйл үндэснээ “-mtayāi, tayāi, yāi” зэрэг дагавар залгаж, уг юмын янз бүрийн шинжийг заах”<sup>2</sup>; А.Бобровников “аль нэг юманд чадамгай, эвсүүрхэн төдийгүй байнга дадамгай байх”<sup>3</sup>; Н.Н.Поппе “үйлийг гүйцэтгэх чадвартай байх”<sup>4</sup>; Б.Х.Тодаева “-mal” дагавартай утгаараа ойролцоо<sup>5</sup>; М.Н.Орловская “үйлийн үр дүнд бий болох чанар ба тухайн үйлийг чадамгай гүйцэтгэх эв дүйг зааж, “tayāi, mqi” дагавартай адил утга илтгэх”<sup>6</sup>; Н.Поппе “үйлдэл хийх авьяас сонирхол, дур хүсэл ба тухайн үйлийг хийх бололцоо, чадварыг илэрхийлсэн утгатай”<sup>7</sup>; Ш.Лувсанвандан “тухайн үйлийг гүйцэтгэхдээ хүсэлтэй давамгайг заасан тэмдгийн нэр үүсгэнэ”<sup>8</sup>; П.Бямбасан “-мхай, мгай, мтгай” дагаврыг үйл үгнээ залгаж, голдуу хүн амьтанд хэвшил дадал болсон зан үйлийн шинжийг заасан тэмдгийн нэр үүсгэнэ (аймхай, түрэмгий, оромхой, аймтгай, очимтгой, ичимтгий)<sup>9</sup> гэх мэтээр үзэцгээсэн байна. Ц.Жанчивдорж багш “-мтгай...” дагавар нь үндсийн уул шинж чанараар зуршил буюу хэвшил болгосон утга бүхий тэмдгийн нэр бүтээнэ (мартамтгай, уурламтгай, очимтгой, үрэмтгий)<sup>10</sup> гэжээ.

Ш.Цэцэнцогт “-matayāi...” дагавар нь “-ma, maqāi, tay, mang, tayāi, mal” гэх мэт тэмдэг үг үүсгэдэг “-ma” бүтцэт дагаврууд гарал язгуур нэгтэй ба “-mta-yā...” дагавартай гарал нэгтэй, утга ойролцоо бөгөөд түүнээс улирч хувирсан байна”<sup>11</sup>

<sup>1</sup> В.М.Котвич. Лекций по грамматике монгольского языка. Петербургъ, 1902, стр.57

<sup>2</sup> А.Попов. Грамматика калмыцкого языка. Казань, 1847, стр.78-79

<sup>3</sup> А.Бобровников. Грамматика монгольско- калмыцкого языка. Казань, 1849, стр.64- 65

<sup>4</sup> Н.Н.Поппе. Грамматика письменно- монгольского языка. М.-Лгр., 1937, стр.104

<sup>5</sup> Б.Х.Тодаева. Грамматика современного монгольского языка. Фонетика и морфология. М., 1951, стр.79

<sup>6</sup> М.Н.Орловская. Имена существительные и прилагательные в современном монгольском языке, М., 1961, стр.87

<sup>7</sup> Н.Н.Поппе. Монгол бичгийн хэлний зүй, Уб., 2012, 70-р т.

<sup>8</sup> Ш.Лувсанвандан. Орчин цагийн монгол хэл. Бээжин, 1961 (1962), 236-р т.

<sup>9</sup> П.Бямбасан. Тэмдгийн нэр. “Орчин цагийн монгол хэл зүй”, Уб., 1966, 114-р т.

<sup>10</sup> Ц.Жанчивдорж. Орчин цагийн монгол хэлний тэмдэг нэрийн тухай, “Заах арга, эрдэм шинжилгээний хуудас”, Уб., 1961, 52-р т.

<sup>11</sup> Ш.Цэцэнцогт. Монгол хэлний үгсийн язгуурын толь. Жанг Жияа Кеу, 1988, 2717-р т.

гээд, дагуур хэлнээ “-γa” нь “ra” болон сэлгэж “-mtə.rə” болдог ажээ. (“içimetegei” гэхийг дагуур хэлнээ “-xitsimtə.re:” гэнэ. Тэрээр, энэ дагавар нь тухайн үйлийг гүйцэтгэх дуртай буюу гүйцэтгэх заншил дадлагатай болсныг илтгэх утгатай. (ayu-mtāqāi, kī-mtegei, soçi-mtāyāi, uquçila-mtāyāi, ukila-mtāyāi, buça-mtāyāi, niçu-mtāyāi, iniyē-mtegei, urba-mtāyāi, уayāra-mtāyāi, kōrbe-mtegei, qolçi-mtāyāi, öber-mtegei) гэсэн бол Ц.Норжин тухайн үйлийг олонтоо хийдэг зан бүхийг илтгэх утгатай (kele-mtegei, yabu-mtāyāi)<sup>12</sup> гэж тэмдэглэжээ. Ц.Норжин энэ дагавар нь “-mtayū (taki-mtayū (тахиж шүтэхдээ сайн, байн байн тахидаг), kündüle-mtegei, umartam-tayū, yabu-mtayū, ire-mtegei) дагавартай гарал нэг гэж үзэж, “-mtayāi” дагавар лугаа ойролцоо утгатай боловч баахан дагаварлах буюу царж хэлэх хандлагатай байдаг” гэсэн байна. Энэ дагаврын тухайд Ц.Норжин “matayāi” гэх дагаврын “m”-ийн арын “a” эгшиг нь гээгдсэн гэж үзсэн нь үе-утгалбар задрах ёстой<sup>13</sup> холбогдоно. Т.А.Бертагаев “-matayāi” дагавар нь тэмдэг нэр бүтээх онцгой дагавар боловч буриад хэлний судалгаанд төдий л дурдсангүй явж иржээ. Энэ дагаврын “-ma” нь “боломж бололцоо”-ны утгатай, цагт нэрийн “-ma, m” дагавар, “-tuγāi” хэмээх ерөөн хүсэх нөхцөл хоёроос бүтсэн иж дагавар (комплексный суффикс- хэлц дагавар (М.Б) гэж үзсэн байна. Жишээ нь, “ogu-matayāi” (оромтгой) нь “ogu-matayāi” гэсэн бүтцээс улиран үүссэн ба “ямар нэг юманд авьяас чадвартай” гэсэн утга бүхий дагавар болно<sup>14</sup> гэжээ. Т.А.Бертагаев энэхүү иж буюу хэлц дагаврын “-γa” нь “qa” болон сэлгэж болох ба “-mataγai, maγāi, maqāi” гурав нь бие биеэ төлөөлөн хэрэглэгдэж болно” гэж үзсэн байна.

Энэ бүхнээс үзвэл “-matayāi” дагаврын “-t/a” нь гээгдэж, “-maγāi” гэсэн хувилбар үүсэж, улмаар “γa” нь “qa” үе-утгалбартай сэлгэж “-maqai” гэсэн хувилбар бүтсэний дээр “-ma” үе-утгалбар нь задарч, дан ганц “-m” бүтээвэр үүссэн байна. Иймээс эрдэмтэд “-matayāi” бүтээврийн оронд голдуу “-maγai, maqai” дагаврыг дурдсаар ирсэн байна. Үүнд: В.Л.Котвич “хийх чадвартай” гэсэн утгатай “-mγāi (ol(u)-mγāi, nekemkei) дагаврын “γai” нь “-qāi” болж, “tasurqāi, quγurqāi, keremkei, ebderemkei” зэрэг үг бүтсэн ба үүнээс “юманд авьяаслаг, хийх дуртай” гэсэн утга бүхий “-rqa-” (sāyi-rqa-, omu-rqa-, sanaγā-rqa-, noya-rqa-) гэсэн дагавар үүссэн<sup>15</sup> гэж үзсэн байна. Тэрээр “-maqāi, maγ (biçimekei, medemer) дагаврыг мөн л “хийн гүйцэтгэх туршлагатай, алив үйлд авьяас чадвартай” гэсэн утгатай гээд, “-mtayāi...” дагаврыг “уг үйл гүйцэтгэх чадвартайн дээр уг үйлийг байнга хийх” гэсэн утгатай гэж тодорхойлжээ<sup>16</sup>. Н.Н.Поппе “үйл гүйцэтгэх чадвартай” гэсэн утгатай “-mγāi” (olomgoi, ha:mγai, iabaamγa (явамгай), “-mqāi” (martamxai, idemxei), “mtai” (вэсэмтеi (бичимтэй), “-ma” (боломж заасан утгатай) (хуреме, sabardama, ylgame)<sup>17</sup> гэсэн дагаврыг дурдсан нь бидний сонирхож буй “-matayāi” дагавартай утга гарлаараа нэг бөгөөд “-mtai” гэсэн дагавар нь “γa” үе- утгалбарыг гээснээс үүссэн байж болох юм. Мөн Н.Поппе “-maγāi, mqāi” хоёр нь нэг дагаврын хувилбар<sup>18</sup> (suru- maγāi,

<sup>12</sup> Ц.Норжин. Монгол хэлний үг бүтээх дагаврын хураангуй, Хөх хот, 2001, 101-р т.

<sup>13</sup> М. Базаррагчаа. Монгол хэлний үе задрах ёс, ЭШБ., №1, Уб., 1996, 41-46-р т.

<sup>14</sup> Т. А. Бертагаев. Лексика современных монгольских литературных языков, М., 1974, стр. 201-202

<sup>15</sup> В. Л. Котвич. Опыт грамматики калмыцкого разговорного языка, Прага, 1929, стр. 113-114


<sup>16</sup> В.Л.Котвич. Лекций по грамматике монгольского языка. Петербургъ, 1902, стр. 67

<sup>17</sup> Н.Н.Поппе. Грамматика бурят- монгольского языка. М.-Лгр., 1938, стр. 90

<sup>18</sup> Н.Поппе. Монгол бичгийн хэлний зүй. Уб., 2012, 70-р т.

martamqāi, untamqāi, idemkei) гэж үзжээ. Тэрээр, үйлээс тэмдэг нэр бүтээх дагаварт “-mqāi” дагаврыг дурдсан байна<sup>19</sup>. Д.Д.Амоголонов “-мгай, мхай” дагавар нь “тухайн юмын чанарыг эзэмших чадвар”-ыг тэмдэглэдэг<sup>20</sup> гэж тэмдэглээд, “-мар/шадмар, дүүмэр (младший), -уу (ёhorx- уу, бүдүүрх-үү) дагавартай утга нэг гэж үзсэн байна. У-Ж.Ш.Дондуков “-нтуу, мтуу” дагавар нь а) үйл гүйцэтгэх чадвартай гэсэн утгатай (яба-мтуу (любящий ходить), марта-мтуу (немного забывчивый), сошо-мтуу (пугливый); б) үйлийн шинж чанарыг заасан (бэлшээлтүү-пасушийся) яарантуу (торопливый)<sup>21</sup> гэж үзсэн нь “-mataγai (mtaγū)” дагавартай гарал нэг ажээ. Тэрээр, “ямар юм байгааг зааж буй, эсвэл ямар нэг юманд чадварлаг буйг заасан (ухаа-мгай, эрэ-мгэй, ханаа-мгай; дуула-мгай (послушный), зоримгой (смелый, решительный) “-мгай” дагавар, “ямар нэг юманд өртөмхий утга, эсвэл “ямар нэг юманд дуртай” гэсэн утгатай. “-мхай” дагавар (сошомхой, аймхай, haamxai; эдимхэй, гоёмхой)-ыг өөр өөр бүтээвэр<sup>22</sup> гэж үзжээ. Мөн А.А.Дарбеева “-мхай” дагаврыг “өртөх, шунах, дурлах” гэсэн утгатай, “-мгай” дагаврыг “ямар нэг юманд чадварлаг авьяастай” гэсэн утгатай<sup>23</sup> гэж үзжээ.

Дээрх хоёр дагавар нь гарал нэг бөгөөд хэрхэн хэлц дагавар болсныг харьцуулбал,



гэсэн байдалтай болох ба “-ta-” нь оруулбар бүтээврийн шинжтэй ажээ. “-m/ ataγai” дагаврын “боломж буюу уг үйл болох нь тулж ирсэн” гэсэн утга бүхий “-ma” хэмээх

үе- утгалбарын эгшиг нь гээгдэн, уул үе- утгалбар задарч, үе төгсгөсөн “-mtaγāi” гэсэн хувилбар үүссэнийг Ш.Цэцэнцогт “-mtaγāi ~ mataγai” (2717, 2730-р т.) гэж тэмдэглээд, -ma, maqai, maγ, maγāi, mal, mta- γū” дагавартай гарал нэг гэж үзжээ. Бидний санавал, дээрх дагавар төдийгүй, erči- m, kerči- m, alqu- m, toqu- m, aγūda- m, čayida- m, erči- m, siqa- m, ula- m, tut(u)- m, oγču- m, taki- m, toγū- m (kötül), čalgi- ma, egere- me (tala), saγā- ma, boγū- ma, čör- me, jaγā- ma, nāyi- ma- n, tū- me- n, čim- bāi ~ čiki- māi, qoki- māi, γuldu- māi, no- mūn, čol- mun, sur- maγ, qāyil- maγ, amaγ- maγ, ir- meg, ara- maγ tara- maγ, bōyira- maγ, saγār- maγ, sire- mel, šuγu- mal, aqa- mad, dūyi- med (degūyi- med), ali- mad, γayiqā- mar, qoyi- mur, talii- mur, yam- bur, ūje- mūri, asara- mji, tara- mčā/ uy, udu- mčir, köke- mdüg, bari-mta, boγū- mta” зэрэг дагавартай гарал нэг ажээ. “-mtaγāi” гэсэн иж буюу нийлмэл хэлц дагаврын “-i” бүтээвэр нь “-γa” бүтээврийн “a” нь “i”-тэй, “γ” нь “y”-тэй тус тус сэлгэж, “үргэлжлэх” гэсэн утгатай ажээ. “sartaγa ki-” гэдгийн “онцгойрох, огцом” буюу “зөгсөхийх” гэсэн утгатай “γa” нь “үргэлжлэх” буюу “эс ялгаран онцгойрох” утгатай “-yi” үе- утгалбараар сэлгэжээ. Энэ тухай акад. Б.Ринчен “bol-ba-i” (болов) гэсэн үйл өгүүлэхүүн гишүүний “-ba-i” нөхцөлийн “-i” авиа- утгалбар нь “... өнгөрсөн цагийн үйл үгийн байдлыг тухайн үйл байдал хэдийн өнгөрсөн боловч өгүүлэгчийн сэтгэлд үргэлжилж одоо байгаа юм шиг тодхон байгааг үзүүлэгч

<sup>19</sup> N.Poppe. Khalkha- mongolische Grammatik. Wiesbaden, 1951, p. 39

<sup>20</sup> Д.Д.Амоголонов. Современный бурятский язык. Улан-Удэ, 1958, стр. 162

<sup>21</sup> У-Ж.Ш.Дондуков. Аффиксальные словообразованные частей речи в бурятском языке, Улан-Удэ, 1964, стр. 92

<sup>22</sup> У-Ж.Ш.Дондуков. Дурдсан зохиол, стр. 78

<sup>23</sup> А.А.Дарбеева. Имя прилагательное, Грамматика бурятского языка, Фонетика и морфология, М, 1962, стр. 117-118

дагавар тул үйл үгнээсээ салгадаггүй нь үйл үгийн бусад дагаврын нэгэн адил<sup>24</sup> гэж тун ч оновчтой тодорхойлсон байна. Ш.Цэцэнцогт “dad-may → dadmayāi, jūyig → jūyirei, qongyur → qong- qurāi, sur- may → surmayāi, qabtaγ → qabtaγāi, qabčiy → qabčiyāi, kelteg → keltegei, qayūr → qayūrāi, γar → γarui, degēl → degelei (ханцуйгүй дээл), qulaγ → qulaγāi, šal → šalāi, qabčiyi- → qabči, urbāyi- → urba-, yudūyi- → yudu, šbttūyi- → šbttu, samayui ~ samayū-n, mayūi ~ mayū, engküre ~ engkürei, nelü ~ nelüi, jabqa → jabqāi, daru- → darūi” зэрэг нэр үйлийн зүйл үгсийг бүтээхэд “i” авиа-утгалбар чухал үүрэгтэй болохыг тэмдэглэжээ<sup>25</sup>. Иймээс “-yi” буюу “-i” авиа-утгалбар нь хөрвөлийн аргаар нэр ба үйлийн аль алиныг бүтээдэг байна. Б.Я.Владимирцов “-mtayāi” бүтээврийн “-γa...”-гийн “γ/ g” нь гээгдээгүй<sup>26</sup> гэж үзээд, “jirumtayāi, bičimtegei” гэж галигласан ба “-āyi” нь “ayī”-гаас, “āyi” нь “oyī”-гоос, “ūyi-” нь “uyī”-гаас, “ūyi-” нь “ügi”-гээс, “iyi” нь “igī”-гээс, “āyi” нь “awī”-гаас, “ōyi” нь “owī”-гоос, “eyi” нь “ewī”-гээс, “ūyi” нь “uwī”-гаас тус тус үүссэн хэмээн үзсэн нь “-γa” нь “yi” болон сэлгэдгийг гэрчилж байна.

“qarčaya- i, malaya- i, jilaya- i, qoyūla- i, amidu- i, engküre- i” гэж эцэстээ “i” бүтээвэртэй үгс байх ба

siru- γa ~ sirū-i

sibe- ge ~ sibe- i

jula- γa ~ jula- i

köke- ge ~ köke- i гэж харьцуулсныг Б.Я.Владимирцовын дээрх

бүтээлээс (стр.295- 298) үзэж болно.

“ayu-ma-(ta)-γai (аймтгай) аюу-м-qai” хоёрыг харьцуулбал оруулбар бүтээвэртэй нь “уг үйлийн шинж эрчимтэй бол оруулбар бүтээвэргүй нь “уул үйлийн шинж эрчим багатай юм. Харин “-γai” нь “онцлон ялгасан”, “-qāi” нь “онцлон ялгаагүй, бүхэллэг” утгыг зааж байх шиг санагдана. Оруулбар “-t/ a-” бүтээвэр нь “өргөөшөө тэлэх, уужимсах” утгатай учир уг тэмдэг нэрнээ “эрчимтэй байх” утгыг нэмдэг байна. Энэ оруулбар “-t/ a-” бүтээвэр нь

gilāyi- (гялайх) ~ gil(t)ayi- (гялтайх)

gilalja- (гялалзах) ~ gil(t)alja- (гялталзах)

gilγana- (гялгана) ~ gil(t)ayana- (гялтганах)

gilas ki- (гялс хийх) ~ gil(t)as ki- (гялтас хийх)

gilγar (гялгар) ~ gil(ta)γar- (гялтгар)

gilang (гялан) ~ gil(t)ang (гялтан)

gilγana (гялгана загас) ~ gil(ta)γana (гялтгана загас)

gilγanaγūr- (гялгануур) ~ gil(ta)γanaγūr- (гялтгануур)

gōliyi- (гөлийх) ~ gōl(t)üyi- (гөлтийх) ~ gōltügene (гөлтгөнө)

- nilāyi- (нялайх) ~ nil(t)ayi- (нялтайх)

nilalja- (нялалзах) ~ nil(t)alja- (нялталзах)

nilayana- (нялганах) ~ nil(t)ayana- (нялтганах)

nilas ki- (нялс хийх) ~ nil(t)as ki- (нялтас хийх)

<sup>24</sup> Б.Ринчен. “Үүрийн туяа” (түүхэн роман), Уб., 1971, 451-452-р т.

<sup>25</sup> Ш.Цэцэнцогт. Монгол үгсийн язгуурын толь, Жанг Жияа Кеү, 1988, 2502-2505-р т.

<sup>26</sup> В.Я.Владимирцов. Сравнительная грамматика монгольского письменного языка и халхаского наречия, Лгр., стр.284, 266-279

- nilaγar- (нялгар) ~ nil(t)аγar- (нялтгар)  
nilаγа- (нялга) ~ nil(t)аγа  
nilаγанаγүг- (нялгануур) ~ nil(t)аγанаγүг- (нялтгануур)  
- babana- (бавнах) ~ bab(tu)na (бавтнах)  
bebene- (бэвнэх) ~ beb(tü)ne (бэвтнэх)  
böbüne- (бөвнөх) ~ böb/ü(tü)ne- (бөвтнөх)  
bübüne- (бүвнэх) ~ büb/ü(tü)ne- (бүвтнэх)  
bubuna- (бувнах) ~ bub/u(tu)na-, bub(tu)na- (бувтнах)  
bobuna- (бовнох) ~ bub/u(tu)na-, bob(tu)na- (бовтнох)  
- ququna- (хухнах) ~ ququ(tu)na- (хухтнах)  
kiquna- (хяхнах) ~ kiqu(tu)na- (хяхтнах)  
qaqana- (хахнах) ~ qaqu(tu)na- (хахтнах)  
küküne- (хүхнэх) ~ күкү(tü)ne- (хүхтнэх)  
- quūkina- (хуухинах) ~ quūki(tu)na- (хуухитнах)  
- šuūkina- (шуухинах) ~ šuūki(tu)na- (шуухитнах)  
šakina- (шахинах) ~ šaki(tu)na- (шахитнах)  
- ebürle- (өвөрлөх) ~ ebür(tü)le- (өвөртлөх), ebürid(ü)le- (өвөртлөх)  
söliyi- (сөлийх) ~ söl(te)-yi- (сөлтийх) (selterkei)  
salayi- (салайх) ~ sal(tā)-yi- (салтайх) (saltas ki-)  
seleyi- (сэлийх) ~ sel(te)-yi- (сэлтийх) (seltes kī-)  
salayi- (салайх) ~ sal(tā)-yi- (салтайх)  
salγana- (салганах) ~ sal(t)аγана- (салтганах)  
- sarāyi- (сарайх) ~ sar(tā)-yi- (сартайх), sartaγar (сартгар)  
sorūyi- (соройх) ~ sor(t)ū-yi- (сортойх), sortuγūr (сортгор)  
sereyi- (сэрийх) ~ ser(t)e-yi- (сэртийх), serteger (сэртгэр)  
sörüyi- (сөрийх) ~ sör(t)ü-yi- (сөртийх), sörtügür (сөртгөр)  
- yöyliyi- (ёйлийх) ~ yol(tu)-yi- (ёлтойх), yoltuγur (ёлтгор)  
- meleyi- (мэлийх) ~ mel(t)eyi- (мэлтийх), melteger (мэлтгэр)  
melegene- (мэлгэнэх) ~ mel(t)egene- (мэлтгэнэх), meleger (мэлгэр)  
melelje- (мэлэлзэх) ~ mel(t)elje- (мэлтэлзэх), melteljegür (мэлтэлзүүр)  
maliyi- (малийх) ~ mal(t)iyi- (малтийх), maltiγar (мальтгар)  
moliyi- (молийх) ~ mol(t)üyi- (молтойх), moltuγur (молтгор)  
moltuγčin (молтогчин)  
möliyi- (мөлийх) ~ möl(t)üs (мөлтөс, ам мөлтөс)  
mölilje- (мөлөлзөх) ~ möl(t)ü (мөлт татах), möli- (мөлөх- элэх хорлох)  
nilаγана- (нялганах) ~ nil(t)аγана- (нялтганах), nilаγar (нялгар)  
- irāyi- (ярайх) ~ ir(t)āyi- (яртайх- ярвайх)  
- kiqua- (хяхнах) ~ kiqu(tu)-na- (хяхтнах), kiqu(tu)naγān (хяхтнаан)  
- čiqua- (чახнах) ~ čiqu(tu)na- (чახнах), čiqu(tu)naγān (чახтнаан)  
- sibene- (шивнэх) ~ sibe(tü)ne- (шивтнэх)  
- šuūkina- (шуухнах) ~ šuūki(tu)na- (шуухитнах) ~ šuūkitunaγān (шуухитнаан)

зэрэг дүрс дуурайх ба хааяа авиа дуурайх үгнээ тохиолдож байна. Энэхүү оруулбар бүтээврийн талаар П.Бямбасан багш “...түүн дээр бас дурдсан “-ай, лз, га, на, р, схий” залгаж болох нэг хэсэг, мөн язгуур дээр нь дурдсан морфемүүдийг

сэр-ий, сэр-лз, сэр-т-гэ-нэ, сэр-т-гэ-р, сэр-гэ-р, сэр-с-хий гэх мэт залгаж болно<sup>27</sup> гэж үзжээ. Өөрөөр хэлбэл, *segeyi-* (сэрийх) ~ *ser(t)eyi-* (сэртийх) гэхчлэн дээр дурдсан шиг “*t*” оруулбар бүтээвэр шургаж болохыг П.Бямбасан багш өгүүлжээ. Жич, дүрслэх үгийн идэвхгүй язгуурт залгаж “-уи” буюу “i” дагавар нь дээр өгүүлсэнчлэн “үргэлжлэх” буюу “жигд нэг хэвэндээ байх” гэсэн утгатай бөгөөд эгшгээр төгссөн үг бүтээвэрт залгаж ордог<sup>28</sup>. Монгол хэлнээ одоо цагийн утгатай “-i” нөхцөл нь “u”-тай сэлгэж, *bu-yu* (буюу) ~ *bū-i*” хэмээх хоёр хувилбар бүтээсэн ажээ<sup>29</sup>. Г.И.Рамстедт энэхүү “-i” нь *dagū-i* (даруй), *muḡū-i* (муруй), *ayisu-i* (айсуй), *ayi-l* (айл), *baḡūgā-i* (буурай), *bala-i* (балай), *ede-i* (ээдий буудай), *üge-i* (үгүй), *ügegū-i* (үгээгүй) зэрэг үгнээ тохиолдож байна гэж үзжээ. Тэр ч байтугай, энэхүү “-i” бүтээвэр нь *sön-i* (шөнө ~ сөнө), *muḡ-i* (муж), *ayuḡūl-i* (аюул), *ükügül-i* (үхүүл) хэмээх нэрийн зүйлд ч орж байна гэж үзсэн нь төрөл хэлнүүдэд “i”-гүй хэлбэрт үг байгаагаас болсон байна. Тэгтэл Б.Я.Владимирцов “*bu-i*” нь одоо цагт нэр (үйлт нэр) нь хөгжлийн явцад одоо цагийн нөхцөл (*bola/ u-i*- болой)-ийн “-i” болон салаалсан гэж үзжээ<sup>30</sup>. Бидний санавал, “*ser-yi-*” зэрэг дүрслэх үгийн “үргэлжлэх” гэсэн утга бүхий “-уи” үе- утгалбар нь “зогсосхийх” гэсэн утгатай “-ya” үе-утгалбараас сэлгэж үүссэн бөгөөд “*bu-i, bu-yu, bola-i*” болон “*dagū-i, ügegū-i, ḡar(u)-i, üge-i, edū-i, murū-i*” зэрэг үгнээ тохиолдож байна. Энэхүү “-i” авиа-утгалбар нь “-ḡagā-i, ḡasā-i, tuḡā-i, ḡtu-i, (-ḡtun), -ḡüjā-i, mū-i, luḡā-i (-luḡā), ba-I (-ba), qu-I (qūn)”<sup>31</sup> зэрэг үйлийн нөхцөлд оролцож явдаг ажээ. Харин Г.И.Рамстедт “-ḡagā-i” хэмээх зөвлөн захирах төгс нөхцөл дэх “-ai” гэсэн хэлбэрийг эрчимжүүлэх бүтээвэр (усилительная частица) гэж үзсэн байна.

“-m/ a-ta-ḡā-i” хэмээх дагавар дахь оруулбар “-ta” нь гээгдвэл “-ma-ḡāi (-мгай) буюу “-ma-qā-i” дагавар салаалсан ба “уг үйлийг богино хугацаанд чадмаг гүйцэтгэх” гэсэн утга илтгэнэ. Жишээ нь: *agu-maḡ/ qāi, sun(u)-maḡ/ qāi, mede-meg/ kei, ayū-maḡ/ ḡāi, iči-mek/ geī, ab(u)-maḡ/ ḡāi, türi-mek/ geī, qari-maḡ/ ḡāi, quḡa-maḡ/ ḡāi, sur-maḡ/ ḡāi, kinu- maḡ/ ḡāi, ḡar-maḡ/ ḡāi, kele-mek/ geī, dad- maḡ/ ḡāi, niḡūr- maḡ/ ḡāi, qaḡū- maḡ/ ḡāi, šū- maḡ/ ḡāi*<sup>32</sup>. Энэ хоёр хувилбарын “-qāi” нь “бүхэл, том, ихсэх; “ḡāi” нь “хэсэг, бага, ялгарах” гэсэн утгатай боловч хэлэхүүний түвшинд төдий ялгарахгүй, саармагшсан шинжтэй юм.

“-maḡāi” хэмээх дагаврын “үргэлжлэх” утга бүхий “i” дагаврыг хасвал “-maḡa” болон “-maḡ” хэмээх нийлсэн хэлц дагавар үүснэ. У-Ж.Ш.Дондуков “-maḡ” дагаврын утгыг 1) ялгарах онцгойрох (*ḡogi- maḡ, ida- maḡ*); 2) шунан дурлах (*qaḡūr- maḡ*); тогтмол шинж чанар (*qoli- maḡ, iḡar- maḡ*); 4) аль нэг байвал (*nḡuyir- maḡ*<sup>33</sup>) гэсэн бол Ш.Цэцэнцогт 1) гүйцэд бус байдал (*aki- maḡ, qaḡur - maḡ, ḡogi- maḡ, qoli- maḡ, duta- maḡ, čida -maḡ*); 2) юмыг нэрлэх (*ači- maḡ, egēde- meg, qali- maḡ, čoči-*

<sup>27</sup> П.Бямбасан. Орчин цагийн монгол хэлний үйл үгийн идэвхгүй язгуурын тухай зарим ажиглалт. “Хэл зохиол судлал”, 16-р боть, Уб., 1987, 18-42-р т.

<sup>28</sup> М.Базаррагчаа. Уйгуржин монгол бичигт урт хос эгшгийг тэмдэглэсэн нь. “Монгол хэлний авианы чөлөөт сэлгэцийн тухай”, Уб., 1992, 107-126-р т.

<sup>29</sup> Г.И.Рамстедт. Введение в алтайское языкознание, М., 1957, стр. 98

<sup>30</sup> Б.Я.Владимирцов. Остатки причастия настоящего времени в монгольском языке. “Работы по монгольскому языкознанию”, М., 2005, стр. 95- 96

<sup>31</sup> Г.Д.Санжеев. Сравнительная грамматика монгольских языков, Глагол, М., 1964, стр. 95- 131

<sup>32</sup> Ш.Цэцэнцогт. Дурдсан зохиол, 2713- 2715-р т.

<sup>33</sup> У-Ж.Ш.Дондуков. Дурдсан зохиол, стр. 90-91

maγ, amaγ- maγ, qāyil- maγ); 3) төстэй буюу холбогдолтой (āyi- maγ, śegēji- meγ, jāyir- maγ, ir- meγ, naγur- maγ, uūji- maγ); 4) тухайн зүйлийн шинж тэмдэгтэй буюу түүгээр дутмаг байх (jegūr- meγ, nōyir- maγ, ege- meγ, qosi- maγ, dura- maγ); 5) тоо хэмжээ заасан (qous- maγ, būira- maγ, aга- maγ tara- maγ)<sup>34</sup> гэх мэтээр ангилсан байна. Энэ дагаврын утгыг Т.А.Бертагаев ерөнхийд нь “үйлийн илрэх боломж буюу дутмаг болох” гэж тайлбарлажээ<sup>35</sup>. Тухайн юмын шинж чанар дутмаг буюу боломж, төсөөтэйн утга бүхий “-maγ” дагавар нь

taγā- ma- (ta)- γā- i → taγā- ma- q/ γā- i → taγā- ma- γ (таавар, тойм, сэжиг)  
qata- γā- ma- (ta)- γā- i → qata- γā- ma- q/ γā- i → qata- γā- ma- γ (шарж хатаасан талх)

śarśa- γā- ma- (ta)- γā- i → śarśa- γā- ma- q/ γā- i → śarśa- γā- ma- γ (царцааж хийсэн идээний зүйл)

saγa- ma- (ta)- γā- i → saγa- ma- q/ γā- i → saγa- ma- γ (далайн алгана загас)

baja- ma- (ta)- γā- i → baja- ma- q/ γā- i → baja- ma- γ (ааруул, архи нэрснээс үлдсэн цагаа)

oγiγā- ma- (ta)- γā- i → oγiγā- ma- q/ γā- i → oγiγā- ma- γ (ороож хийсэн юм, зэс ороомог)

śarśa- ma- (ta)- γā- i → śarśa- ma- q/ γā- i → śarśa- ma- γ (ээзгий зэргийг шар тосонд царцаасан нь)

→ čida- ma- q/ γā- i → čida- ma- γ (сурамгай, дадамгай)

tara- ma- (ta)- γā- i → tara- ma- q/ γā- i → tara- ma- γ (армаг тармаг)

nuūr- ma- (ta)- γā- i → nuūr- ma- q/ γā- i → nuūr- ma- γ (нуурам тогтуун)

jaγūr- ma- (ta)- γā- i → jaγūr- ma- q/ γā- i → jaγūr- ma- γ (зуурч хийсэн нь)

jaśa- ma- (ta)- γā- i → jaśa- ma- q/ γā- i → jaśa- ma- γ (засах төлөвтэй, агталсан)

śala- ma- γā- i → śala- ma- γ (гавшгай түргэн, хурдан)

qaγūr- ma- (ta)- γā- i → qaγūr- ma- q/ γā- i → qaγūr- ma- γ (хуурамч, худал)

kerči- me- (te)- ge- ī → kerči- me- k/ge- ī → kerči- me- g (шөлөнд хөшиглөх гэдэс дотор)

sigū- me- (te)- ge- ī → sigū- me- k/ge- ī → sigū- me- g (шүүр шанага, хэвлээгүй үйрмэг бяслар)

türki- me- (te)- ge- ī → türki- me- k/ge- ī → türki- me- g (түрхэх юм)

gūyi- me- (te)- ge- ī → gūyi- me- k/ge- ī → gūyi- me- g (зэрвэс гүйцэтгэх) зэрэг үгстэй ихэвчлэн ойролцоо утгатай болох ба “-ma- (ta)- γā- i” нь “-ma- q/ γā- i” дагаврын хувилбар болно. Үүнд оруулбар дэд бүтээвэр нь уг үйлээс үүссэн тэмдэг нэрнээ зөвхөн “яльгүй онцлон ялгасан буюу бяцхан эрчим нэмэх төдий” утга оруулдаг ажээ.

Г.И.Рамстедт “Үйл үгээс үүссэн “-γāi ~ qāi...” дагаврын хажуугаар мөн ийм дагавраар нэрээс үүссэн үг олонтоо дайралдаж байна. Энэ хоёрын язгуур нь анх нэр үйлийн аль нь байсныг зарим тохиолдолд ялгахад бэрх байдаг. Үүний “-γāi” нь ихэвчлэн багасгах утгатай байдаг. Жишээ нь: tara-γāi (халзан), jōgē-kei (зөөхий), činu- qai (чонохой, чонын бэлтрэг), kei-kei (хүүхэй), soluγāi (солгой- зүүн тал), čul- γa/ ui (цулгай), gūnjegei (гүнзгий), malaγāi ~ malaqai (малгай), aγuqāi (архай, ар тал),

<sup>34</sup> Ш.Цэцэнцогт. Дурдсан зохиол, 2713- 2715-р т.

<sup>35</sup> Т.А.Бертагаев. Дурдсан зохиол, стр. 202

gergei (гэргий)<sup>36</sup>.

Бидний үзсэнээр “-ya...” үе- утгалбарын “a” нь “i” -тэй сэлгэж, улмаар “y” нь “y” -тэй сэлгэж, “yi” гэсэн үе- утгалбар үүсэж, “y” нь гээгдэн, “i” нь өмнөх эгшигтэй нийлж, хэлц хос эгшиг, тухайлбал “-ma-i” гэсэн дагавар бий болжээ. Энэ дагавар нь “-maᠢ”, “maᠢ” дагавартай гарал нэг болно. Г.И.Рамстедт нэрээс тэмдэг нэр бүтээх “-mai” дагаврын “tala-māi (тэгш, хавтгай), jaᠢal-mai (загалмай), naᠢ-mai (бүх), nouᠢr-mai (нойрмог), qoᠢ-mūi (“qoᠢ” нь халаас, саадаг), ere-meᠢ (эрмэй- эр-), naᠢyᠢr-maᠢ (нуурмаг)<sup>37</sup> зэрэг жишээ татаж, ere-meg (эрмэг гүү), kir-maᠢ (анхны цас), kiraᠢyᠢ (хяруу) гэсэн жишээг харьцуулжээ. Тэрээр, “-ma, -maᠢ (qolimaᠢ), -ma (tar-ma-), -m (udu-m, ula-m, (ulaᠢā, ulari- bari- m, quri- m, jiru- m, erde- m, aᠢyūda- m, qoᠢj- m, aᠢyu-m-siᠢy), -maᠢ (čida-maᠢ, ida- maᠢ), -mal (tari- mal, biči- mel), -mta (boᠢyū- mta, daru- mta, bari- mta, jaᠢᠢya-mta, tö᠒ürü- mte (бөгж, tö᠒ür-) i- mji (ergü-mji, neᠢyle- mji, üle-mji, ula-mji); -mᠢāi, mtaᠢāi, mtaᠢyᠢ (martam- qāi, ide- mkeᠢ, ūyila- mᠢqāi, sočima- yāi); -mᠢi, mi, m (a- mūi, am, am) зэрэг дагаврууд нь нэг эхтэй болохыг дурджээ<sup>38</sup>.

Ийнхүү оруулбар дэд бүтээврийн жишээг монгол хэлний дүрслэх үгийн үндэс болоод тэмдэг нэр бүтээх дагавар дотор шурган орсон “-tu-” болон “-ta-“ үе- утгалбараар гаргахыг оролдлоо.

З.А.Потиха “орос хэлнээ об + вернуться → обернуть(ся), об + влако → облака” гэх мэтээр “в” авиалбар гээгдэх на- в- острить (острый), в- отчина (отчий) гэхчлэн “в” авиалбар нь оруулбар бүтээвэр болжээ<sup>39</sup>. Иймэрхүү авиа-утгалбар дүрслэх үгийн дундаас “харжигнах-хажигнах, бархирах-бахирах, дэрдийх-дэрийх, дэдийх, ханхайх-хахайх” гэх мэтээр “р, н, д” зэрэг авиа-утгалбар гээгдэх нь монгол хэлнээ тохиолддог<sup>40</sup> Е.А.Земская “Орос хэлний үг бүтэх ёсноо авиалбар сэлгэх нь бүтээврүүдийн уулзварт төдийгүй, тухайн үгнээ тодорхой утгагүй хэрчим буюу хэлбэртэй холбогдох заагт тохиолддог. Авиалбарын бүрэлдэхүүн ба сэлгэцээрээ бүтээвэртэй тохирч буй утгагүй хэрчмийг дэд бүтээвэр гэнэ. Энэ нь бүтээврээс доод түвшний нэгж болно”<sup>41</sup> гэж дэд бүтээврийг тодорхойлжээ. Орос хэлнээ “любимый→ любим- ец, любимч- ик; сын→ сын- ок→ сыноч- ек; простой→ прост- ак→ простич- ок” гэвэл “-ец, ик” нь дагавар, чепец→ чепч- ик, чулок→ чулоч- ек, замок- замоч- ек, конец→ кончи- к” гэвэл “-ек, ик” нь дэд бүтээвэр болох ажээ. Е.А.Земская дэд бүтээвэр нь эртний үгсийн бүтцийн үлдэц бөгөөд өмнөх үндэс язгууртайгаа зууралдан энгийншсэн буюу угшсан ажээ. Ингэж үгийн үндэс дагавар хоёрын ялгаа арилах нь бүтээврийн авиалбар зүйн түвшинд буюу дэд бүтээврийн түвшинд үргэлж давтагдаж байдаггүй” гэж үзжээ<sup>42</sup>. Иймэрхүү энгийнших (опрошение) ёс монгол хэлнээ “ebed- čin (өвчин), geᠢyᠢ- čin (гийчин), qaᠢyᠢ-čín (хуучин), qaᠢyᠢ- čí (хууч), ónᠢ- čin (өнчин)<sup>43</sup>, jiᠢya- čin (загасчин), dāyᠢ- čin (дайчин)” гэхэд “-či-n” дагавар нь язгууртайгаа нягт нийлж дэд бүтээвэр болсон

<sup>36</sup> Г.И.Рамстедт. Дурдсан зохиол, стр. 184-185

<sup>37</sup> Г.И.Рамстедт. Дурдсан зохиол, стр. 193

<sup>38</sup> Г.И.Рамстедт. Дурдсан зохиол, стр. 100- 105

<sup>39</sup> З.А.Потиха. Современное русское словообразование, М., 1970, стр. 131-133

<sup>40</sup> М.Базаррагчаа. Монгол хэлний авиа сэлгэх ёс. Уб., 1987, 178-179-р т.

<sup>41</sup> Е.А.Земская. Современный русский язык. Словообразование, М., 1973, стр. 81

<sup>42</sup> Е.А.Земская. Дурдсан зохиол, стр. 82

<sup>43</sup> М.Базаррагчаа. “Өнчин” хэмээх үгийн гарал. МУИС., Scientipic journal, N 6, Уб., 1995, 16-24-р т.



байх ба зарим түүхэн гарвалын үүднээс язгуур дагавраар задарч болохуйц авч “aduу- ёi- n, mal- ёi- n” гэсэн дагавраас өөр юм. Академич Б.Ринчен genel (гэрэл), gere (гэр, загас гэрдэх), gegēn, gegegēn (гэгээн), geуi- (гийх), geуigūlūgсi (гийгүүлэгч)<sup>44</sup> зэрэг үгсийг “ge-” гаралтай гэжээ.

Энэхүү “-ёin” бүтээвэр нь Е.А.Земскаягийнхаар дэд бүтээврийн нэг төрөл хувилбар болох юм.

И.А.Мельчук “палец” гэдгийн “-ец” нь дэд бүтээвэр болох бол “пе(ть) → певец” хэмээх үгийн “-ец” нь дагавар болно гэж үзсэн ба тэрээр “Бүтээврийн адилаар зарим нэг үндэс язгуурт залгаж болох боловч утгагүй, зөвхөн цэвэр хэлбэрийн махбодь болж чаддаг зүйл хэл шинжлэлд тохиолддог. Түүнийг бид дэд бүтээвэр гэж болно”<sup>45</sup> гэж тодорхойлсон нь Е.А.Земскаягийн үзсэнтэй ижил байна. Ийнхүү бүтээврийн гаргалгын хувьд, дэд бүтээвэр нь үг бүтээх дагавартай тохировч дагавар шиг бие даасан утгагүй юм. И.А.Мельчук франц хэлний “cev” гэсэн дэд бүтээвэр нь “reservoir (хүлээн авах, хүртэх), concevoir (ойлгох, учрах), décevoir (мэхлэх, урам хугарах), recevoir (мэдрэх, ойлгож авах)” зэрэг үгнээ тохиолдох авч өөр дагавартай дүйцдэггүй байна” хэмээгээд, энэхүү “cev” нь ховор тохиолддог дэд бүтээвэр болох (Үүнтэй монгол хэлний “-t/ a-” гэсэн оруулбар дэд бүтээврийг харьцуулна уу) ба “cev” нь нэлээд олон үгнээ тохиолдож, франц хэлний язгуур мэт сэтгэгддэг. Мөн франц хэлний угтвар “re-, dé...” бүтээвэртэй заримдаа тохирох дэд бүтээврийн дараа “cev” гэсэн дэд бүтээвэр орох бөгөөд “cev ~ sov ~ соiv ~ серt” (réception- хүлээн авалт, perceptible (хүлээн авч буй) гэж авианы сэлгэцээр ялгарах нь франц хэлний үйл үндсэнд байнга тохиолддог<sup>46</sup> гээд, “cev, соi, соiv, серt” зэргийг бүтвэрэнцэр (морфоид) гэж болохгүй, дэд бүтээвэр юм гэжээ. Тэрээр, “ceiv ~ серt” гэсэн махбодь нь англи хэлний “receive-хүлээн авах; conceive (учрыг нь олох), deceive (хуурах мэхлэх), perceive (хүлээн авах), reception (хүлээн авалт), conception (чиглэл, хандлага), deception (хуурмаг), perception (хүртлэг) зэрэг жишээнд тохиолдох бөгөөд мөн “-tain” гэдэг дэд бүтээвэр нь англи хэлний detain (хүчээр барих), obtain (хүлээн авах), retain (барих, хадгалах), maintain (дэмжих, хадгалах) зэрэгт оролцдогийг И.А.Мельчук тэмдэглээд, энэ дэд бүтээвэртэй таарах бүтээвэр нь франц хэлний үйл үгнээ тохиолдох “ten” гэсэн бүтвэрэнцэр байдаг гэжээ. Тэрээр, бүтвэрэнцэр нь франц хэлний “lunette” (жижиг сар) гэхэд орсон “багасгах” утга бүхий “-elte-” хэмээснийг хэлэх<sup>47</sup> ба энэ нь хэвшмэл бүтээвэр (фразеологизованные или лексикализованные комплексы морф, морфологические фраземы) болох ажээ. Ингэж дэд бүтээврээс бүтвэрэнцэр нь утгын улбаатай байдгаараа ялгаатай юм. Монгол хэлнээ “aya-s (аяыг нь /аясыг нь дагах), игма-s / урам зориг), ёуi-s (үед, орчимд, тухайн үес) зэрэгт орсон “-s” нь олны утга нь ихэд бүдгэрсэн тул бүтвэрэнцэр болж, “uridu-s (урьдын хүмүүс), erdeni-s (эрдэнийн зүйлс), тoёi-s (олон мөч), беке-s (бэхний олон тоо) зэрэг үгсийн “-s” (олон тоо) дагавраас ялгаатай юм. Т.А.Бертагаев “аж амьдрал, аж байдал, аж үйлдвэр, аж ахуй, аж төрөх” гэсэн холбоо үгсийн “аж”, “суга тат-, суга үсэр-” гэсэн холбоо

<sup>44</sup> Б.Ринчен. Монгол бичгийн хэлний зүй, Дэд дэвтэр, Авиан зүй. Уб., 1966, 146-147-р т.

<sup>45</sup> И.А.Мельчук. Курс общей морфологии. Т.IV. Москва- Вена, 2001, стр. 282- 283

<sup>46</sup> И.А. Мельчук. Дурдсан зохиол, стр. 284

<sup>47</sup> И.А. Мельчук. Дурдсан зохиол, стр. 95,280

үгсийн “суга”, “цав цагаан, шав шар” гэдгийн “цав, шав” зэргийг бүтвэрэнцэр буюу угтвар бүтвэрэнцэр (префиксоиды)<sup>48</sup> гэж үзсэн билээ. Мөн дүншаан хэлнээ хулан → ху(пу)лаган (улаан → час улаан), шира → ша(бэ)-рги (шар → шав шар) гэж тэмдэг нэрийн давуу зэргийг илтгэх оруулбар бүтээвэр (инфикс) гэж үзсэн нь бүтвэрэнцрийн нэг хувилбар болно. М.Энхжаргал “-su-n” (-s) хэмээх дэд бүтээврийн утгыг 1.үйлийн үр дүн хийгээд үр дүнд бүтсэн нэр (нэмнээ-с, нугалаа-с); 2.үйлийн багаж хэрэглэгдэхүүн (тушаа-с, уяа-с, түгжээ-с); 3.үйлийн байр байдал заасан нэр (тавиа-(с)-тай, ноёлоо-(с)-той) гэж ангилсан байдгийг<sup>49</sup> энэ тухайд дурдъя.

И.А.Мельчук нийлмэл хэлц бүтээврийн тухай “Өгүүлбэрийн гишүүдийг бүтээж байгаа энгийн хэсэг болдог тэмдгүүд хэвшсэн хэлц болохыг бүтээврийн хэлц (морфологические фраземы)” гэж тодорхойлоод,

1) язгуур + язгуур (хэвшмэл нийлмэл үндэс)

2) язгуур + дагавар (дагавар + язгуур) (үүнд хэвшмэл дагавар ба нөхцөлүүд хамаарна)

3) дагавар + дагавар (хэвшмэл иж дагавар) гэж хэвшмэл бүтээврийг ангилж, эдгээрээс тухайн бүтээвэр нь бие даасан шинжээ алдаж, бүтвэрэнцэр болох нь буй. Үүнийг хуурмаг бүтээвэр (квазиморфема- квазиморф) гэдэг байна<sup>50</sup>. Бидний санавал, CV гэсэн үе-утгалбар нь язгуур дагавар нөхцөл болон угтвар оруулбар бүтээврүүдэд орохдоо өөр хоорондоо агуулга гаргалгын талаар нэгдэж, нийлмэл хэлц бүтээвэр үүснэ. Монгол хэлний *bara-γün, je-gün, čina-γün, ina-γün, ala-γün* (үүд орчим газар), *tüü-gün* (өмнө), *teri-gün, degē-gün, doüra-γün, dotura-γün, dergede-gün, ečine-gün, qöyina-γün, -ečine-gün, urida-γün, jaqa-γün, öyira-γün, dotu-γün*<sup>51</sup> зэрэг орон цагийн утга илтгэх “-γün” дагавар нь идэвхтэй идэвхгүй язгуурт залган орж буй. Үүнээс идэвхгүй язгуурт залгасан нь хэвшмэл хэлц бүтээврийн шинжтэй юм.

*čina-γün, čina-γ-si, ina-γün, ina-γ-si, čina-du, ina-du, čing-gi-jü, ing-gi-jü* зэргийн “či-“үе-утгалбар нь “ta ~ ti” үе- утгалбараас “t ~ č”-гийн сэлгэцээр үүссэн ба “ta ~ či” гэсэн хоёрдугаар биеийн төлөөний үг ч эдгээр үгтэй гарал нэг юм. Цаашилбал: “te-yī-n, e-yī-n, te-yī-mü ~ i-yī-mü, te-n-de ~ e-n-de, te-gū-n ~ e-gū~n, te-dü-ī ~ e-dü-ī” зэрэг заах төлөөний үгтэй болон гуравдугаар биеийн ганц олон тоот “a ~ i” төлөөний үгтэй гарал нэгтэй болно. Иймээс “či-na...” үндэс нь “či-na” гэсэн үе-утгалбараас үүсэж, нэгэнт хэвшмэл хэлц үндэс болжээ. Үүний “-na” гэсэн хоёрдахь үе- утгалбар нь өгөх-оршихын “-a” нөхцөл “үндэс үүсгэх “-n” бүтээвэртэй нийлж, či-n-a → ta-n-ā (танаа өргөдөл барих) гэснээс “čina-” гэсэн үндэс болж, хэвшмэл хэлц бүтээвэр бий болжээ. “či-n-a”-гийн “-n” нь “-m”-тай сэлгэж, “či-ma-” гэсэн үндэс үүсжээ<sup>52</sup>. Ийнхүү үе-утгалбар нь “C-V” болон задарч, өөр өөр бүтээвэр буюу үндэс бүтээх “-n ~ m” өгөх-оршихын “a” нөхцөл болсон боловч өөр хоорондоо нийлж, či-n-a-, či-m-a гэж байснаа čina-, čima- гэсэн хэлц бүтээвэр болсон байна. Т.А.Бертагаев “явнам” гэхэд одоо цагийн “-на” нөхцөлд ирээгүй цагт “m” нөхцөлийг залгасан гэж

<sup>48</sup> Т.А.Бертагаев. Морфологическая структура слова в монгольских языках, М., 1969, стр. 24-28

<sup>49</sup> М.Энхжаргал. Монгол хэлний “-с” дэд бүтээврийн утга, үүрэг, найруулгын онцлог. “Оюуны хэлхээ”, ЭШБ., 12-р боть, Уб., 2014, 76-84-р т.

<sup>50</sup> И.А. Мельчук. Дурдсан зохиол, стр. 453, 458

<sup>51</sup> Ш.Цэцэнцогт. Монгол үгсийн язгуурын толь, Жанг Жияа Кеү, 1988, 2625-2626-р т.

<sup>52</sup> Хасбаатар. Монгол манж хэлний нэгдүгээр биеийн төлөөний нэрийн тухай харьцуулал, ӨМИС., ЭШ-ний сэтгүүл, 1992, №3, 23-р т.

үзсэн бөгөөд “-γ-san, m/a- taγū, ug-gi-n-᠑a/ ir дагавруудыг нийлмэл хэлц дагавар<sup>53</sup> гэжээ.

Түүнчлэн хэлц бүтээврийн аль нэг авиа-утгалбар нь гээгдэж, хувилбар үүсэх нь монгол хэлний үйлдэгдэх хэвийн дагаварт тохиолдоно. Жишээ нь: үйлдэгдэх хэвийн “de ~ te...” хувилбарын “-de” нь “-l”-ээр төгссөн үгнээ “-te” нь “b, γ, r”-ээр төгссөн үгэнд залгадаг. П.Бямбасан “Харин “-de ~ te” хоёр нь “-γda...” хувилбараасаа салж байгаа морфем зааглагдах үзэгдэл байж болно<sup>54</sup>” гэж үзсэн ба хэлц бүтээврийн “γ” гээгдэх нь оруулбар бүтээврийн нэг өвөрмөц тохиолдол болно. Тухайлбал, deγl-de- (дийлдэх) ~ deγilγgde- (дийлэгдэх), duγl-da- (дуулдах) ~ daγlā-γda- (дуулагдах), qaγūr-ta- (хууртах) ~ qaγūru-γda- (хуурагдах), sonus-da- (сонсдох) ~ sonusu-γda- (сонсогдох), ög-ke- (өгтөх) ~ öggūgde- (өгөгдөх), ab-ta- (автах) ~ ab(u)-γda- (авагдах) (?) qan-ta- (хантах) ~ qon(u)-γda- (ханагдах-хангагдах), sur-ta- (суртах) ~ sur(u)-γda- (сурагдах) (?), kūr-te- (хүртэх) ~ kūr(ü)-gde- (хүрэгдэх) (?), ol-da- (олдох) ~ ol(u)γda- (ологдох) (?), bol-da- (болдох) ~ bol(u)-γda- (бологдох) (?) гэх мэтээр “-γ/g-” гэж, “-γda-” гэсэн хэлц дагавар хагасарчээ. Үйлдэгдэх хэвийн энэ хоёр хувилбар нэг үндэснээ давхарлан “qaγūr-ta-γda- (хууртагдах), ab-ta-γda- (автагдах), kūr-te-gde- (хүртэгдэх), deγl-de-gde- (дийлдэгдэх)” гэх мэтээр хэлэгдэж, нийлмэл хэвийн ховор тохиолдол байж болох ажээ.

А.Н.Тихонов, Р.И.Хашимова нар нэвтэрхий толь бичигтээ “Дэд бүтээвэр нь бие даасан бүтээвэртэй адил мэт байх боловч үг бүтээх ба хувилгах бүтээврийн авиалбар зүйд чухал үүрэг гүйцэтгэдэг чухал нэгж мөн<sup>55</sup>” гэж тодорхойлсныг эцэст нь дурдахын зэрэгцээ Ш.Цэцэнцогт үйлээс нэр бүтээх “-dal” дагаврыг “-γda” гэсэн үйлдэгдэх хэвийн дагаварт үйлээс нэр бүтээх “-l” дагавар залгаж, уул хэвийн “-γ” гийгүүлэгч- авиалбар гээгдэж, “-da-l” гэсэн хэлц бүтээвэр болсон<sup>56</sup> гэж үзсэн байх ба Г.И.Рамстедт “ükü-del, bāyi-dal, yabu-dal” зэрэг үгийн “-da-” нь үйлдэгдэх хэвийн “-da...” (-γda...) дагавраас эхтэй<sup>57</sup> гэж үзсэн байна.

Бидний бодвоос, “-γda...”-ын “γ” нь а) “бусдаас ялгарах” → “бусдаар үйлдүүлэх” гэсэн утгатай “-γa ~ qa, γū-l, l-γa” дагавар, б) “бусдаас ялгарах → одоо ба ирээдүй цагт үргэлжлэх; байнгад байх” (o᠑i-γā+ edüi, yabu-γā, oγul᠑a- γā), в) “бусдаас ялгарах → өчүүхэн болж ялгарах → жижгирэх” (a᠑i-γda-, a᠑i-γtun, üje-gsen) гэсэн утга ба авианы хувирлаас үүссэн бөгөөд “-γa...” үе-утгалбарын эгшиг нь гээгдэж, “-da” дагавартай нийлж, өөрийн эрхгүй үйлдэгдэх “-γda” гэсэн нийлмэл хэлц дагавар үүсжээ. Энэхүү “-γda”-ын “-da” нь “өөрийн эрхшээлд оруулах” (gejige-de-, bilegü-de-, ama-da-, daγū-da-), “үг юмын хэтэрч, зохисгүйдэх” (ilegü-de-, maγū-da-, γasiγū-da-, möküs-de-, γomu-da-, qo᠑i-da-) гэсэн утгатай “-da” дагавраас үүсэлтэй биз. Учир нь, бусдын эрхэнд аяндаа үйлдэгдэх үйл нь “-da” дагаврын “алив юмс давхарлах → дээшлэх → “хүч давхарлах буюу ихсэх” ба “давтах” → хүчирхэх, зохисгүйдэх” гэсэн утгатай холбогдох болно. “ke᠑egü-de-, dabāγā-da-, qomsa-da-”

<sup>53</sup> Т.А. Бертагаев. Дурдсан зохиол, стр. 54-55

<sup>54</sup> П.Бямбасан. Орчин цагийн монгол хэлний үйл үгийн хэв байдал. “Хэл зохиол судлал”, 2-р боть, Уб., 1970, 259-р т. “Монгол хэлний онол бүтцийн асуудал”, Уб., 2006, 155-р т.

<sup>55</sup> А.Н.Тихонов, Р.И.Хашимова и другие. Энциклопедический словарь-справочник лингвистических терминов и понятий. Русский язык. Т.1. М., 2008, стр. 649

<sup>56</sup> Цэцэнцогт. Монгол үгсийн язгуурын толь, Жанг Жияа Кеу, 1988, 2797-р т.

<sup>57</sup> Г.И.Рамстедт. Введение в алтайское языкознание, М., 1957, стр. 133

гэвэл “хүч үл хүрэн зохисгүйдэх”, “sinā-da-, čilayū-da-, tasiyūr-da-, qola-da-” гэвэл “хүч хэтэрч зохисгүйдэх” буюу ”хүчээр уг юманд дарангуйлах, хүчирхэх” утга илтгэх тул үйлдэгдэх хэвийн дагаварт голлох махбодь болон оржээ. Ийнхүү аливаа хүчинд өөрийн эрхгүй өртөж, улмаар “üje-gde-, bodu-γda-, yabu-γda-, soru-γda-, čida-γda-, čina-γda-, seǰigle-gde-, kürge-gde-, yegüdge-gde-, durusu-ǰda-, toquā-γda-” гэхчлэн хэлэлцэх ба Г.Д.Санжеев “энэ хэв нь түүхэн үүднээс үйлдүүлэх хэвээс үүссэн”<sup>58</sup> гэж үзсэн нь “-γa...” үе- утгалбарын авиа утга хоёрын түүхэн хувьсалтай холбогдоно.

### РЕЗЮМЕ

В монгольском языке субморфы, не обладающие конкретным значением встречаются не только в конце слова или в разных суффиксах, но и внутри корня. Это можно назвать инфиксальным субморфом. При сравнении слов “gil- γana- (сверкать, блестеть) и gil- ta- γana- (блестеть, сверкать) суффикс “-ta” в последнем слове можно назвать инфиксальным субморфом, так как он не имеет определённого значения. Но с точки зрения терминологии с помощью этого инфиксального субморфа “-ta” образуются слова “giltayanaγūr” (слюда) и “gilγanaγūr” (блестящий, щеголеватый) с разным значением. Кроме вышеназванных изобразительных слов редко наблюдаются инфиксальные субморфы в знаменательных словах. ebürle- (спать вместе, класть за пазуху). ebür- tū- le- (спать вместе, класть за пазуху). Со стороны фонеморфологии или морфонологии в морфемном шве выделяются субморфы, что ждёт своего исследования на новом уровне.

---

<sup>58</sup> Г.Д.Санжеев. Сравнительная грамматика монгольских языков. Глагол, М.,1964, стр. 44